

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ГУЧИН НЭГДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны аравдугаар сарын 29-ны 14 цаг 03 минутад эхэлж, 15 цаг 50 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 47 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Хөдөлмөрийн яамны зарим ажилтныг удирдах албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none">- Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар- Санхүү, эдийн засгийн газрын даргын албан тушаалд томилуулахаар	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Гончигдашийн Сувдааг Хөдөлмөрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Бавуугийн Пүрэвсүрэнг Хөдөлмөрийн яамны Санхүү, эдийн засгийн газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр</p>

		<p>дэвшүүлж, Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирлын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Ганхуурайн Баттунгалагийг Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирлын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуягт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>УИХ-ын Тамгын газар, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн Б.Батгэрэлийг “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэж, төрийн захиргааны албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх 2. Б.Батгэрэлийг “Нийтийн</p>

албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилохыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад үүрэг болгох

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 4 иргэнийг "Дэс түшмэлийн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэх

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан "Дэс түшмэлийн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 1 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх

3. Нэр дэвшүүлсэн иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

		<p>сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилохыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга А.Хүрэлшагайд үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нэр, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай</p>	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалтыг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн "Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөл"-ийн нэрийг "Эрүүл мэнд, спортын яамны дэргэдэх салбар зөвлөл" гэж өөрчилж, бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн батлах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) Төрийн нарийн бичгийн дарга, 2) Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, 3) Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга 4) Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга 5) Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, 6) Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга 7) Төрийн захиргааны удирдлагын газрын яамны хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн <p>2. Энэ тогтоол гарсантай</p>

		<p>холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 16 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 1а/4306 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэнд, спортын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын яамны хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Нармандахын Оюундэлгэрийг 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн томилох. 2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын “нэг”-ийн 1 6-д “Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Сэнгээгийн Гантуяа” гэснийг хүчингүй болсонд тооцох 3. “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Оюундэлгэрт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
5	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авсан арга хэмжээ, ахиц дэвшил, үр дүн" сэдвээр Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлийн даргын сонсгол сонсож, " хэлэлцэх тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3, 39 дүгээр зүйлийн 39.6, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.4 дэх заалтыг тус тус баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар</p>

		<p>сарын 29-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөл нь чиг үүргийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг хангалттай зохион байгуулж байна гэж дүгнэх2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа эрчимжүүлж ажиллахыг салбар зөвлөл /П.Бат-Өлзий/-д үүрэг болгох3. Төрийн албаны зөвлөлийн шийдвэр, Ажлын албанаас өгч буй зөвлөмж, Ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу тодорхой ажил зохион байгуулж, хэрэгжилтийг салбар зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайлангийн хамт 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг салбар зөвлөл /П.Бат-Өлзий/ -д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба С.Цэдэндамба/-нд тус тус даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА